

“ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ” ОНӨААТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИННИЙ 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2026 оны 05 дугаар сарын 29

Улаанбаатар хот

д/д	Хүрэх үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Зорилтот түвшинд хүрсэн эсэх (тоон утга)	Тайлбар	Дүн (хувь)
				2023 он	2025 он				
1	Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдлыг 29.5 хувиар бууруулж, нийт агаарын чанарыг 15.5 хувиар сайжруулна.	Гэр хорооллын 103.090 өрхийг LNG, LPG хий, цахилгаан, сэргээгдэх болон бусад эх үүсвэрт шилжүүлнэ	Өрхийн тоо			Бусад эх үүсвэрт шилжүүлсэн өрх, тоо	4835	Нийслэлийн Засаг даргын Захирамжаар Чингэлтэй, Баянгол дүүргийн 5000 өрхийг хийн халаагуурт шилжүүлж байна. Чингэлтэй дүүргийн 7, 8, 9, 10, 11, 12, 13, 15, 16, 17, 20, 21, 22, 23, 24, Баянгол дүүргийн 11, 16, 22, 23 хороодод 4250 айл өрхөд хийн зуух суурилуулсан. Чингэлтэй 3474, Баянгол дүүрэгт 776 хийн халаагуурт шилжсэн өрхийг http://tttsevice.mn/ программд холболт хийж газ мэдрэгч төхөөрөмж суурилуулж хяналтад авсан. Эхний хагас жилийн байдлаар 26481 удаагийн хийн халаагуурын эрсдэлийн дуудлага бүртгэгдэж зөвлөгөө, мэдээлэл өгч хариуцагч газруудад мэдээлэл өгсөн.	96.7
2		Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд агаар	Нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын			Хэрэгжилт хувь	100	Нийслэлийн Засаг даргын захирамжийн хүрээнд 100квт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн тооллогыг 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 04 дүгээр сарын 07-ны	100

	Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн хяналтыг сайжруулна.	бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулна.	явц, хувь					өдрийн хооронд зохион байгуулсан. Нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 100-4200 кВт хүртэлх хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж магадлан итгэмжлэх ажлын хүрээнд усан халаалтын 91 байршлын 201 зуух, технологийн зориулалттай уур үйлдвэрлэх 91 зууханд хяналт шалгалт хийсэн	
--	--	---	--------------	--	--	--	--	--	--

ХЯНАСАН:
ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.БАТТУЛГА

Ц.БОЛОРМАА

“ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ” ОНӨААТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-
2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИНИЙ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2026 оны 05 дугаар сарын 29


Улаанбаатар хот


Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Чингэлтэй, Баянгол дүүргийн 5000 айл өрхийн хийн халаагуурт шилжүүлсэнтэй холбогдуулан 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт 4835 айл өрхийн газрын хийн мэдрэгч төхөөрөмжийг /LoRaWAN Transmitter/ <http://ttt.service.mn/> системд бүртгэсэн. Хяналтын дэлгэцэнд ирж буй дохио дамжуулсан 23751 өрхийн 71253 иргэнийг угаарын болон газрын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан байна.



Газын мэдрэгч дохио дамжуулж холбогдсон өрхийн тоо





Хяналтын дэлгэцэд ирж буй газрын хий мэдрэгч төхөөрөмжийг дэлгэцийн операторууд 24 цагаар хянаж байна.

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 100-4200 кВт хүртэлх хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж магадлан итгэмжлэх ажлын хүрээнд усан халаалтын 96 байршлын 206 зуух, технологийн зориулалттай уур үйлдвэрлэх 90 зууханд Нийслэлийн Агаар, орчны бохирдолттой тэмцэх газрын байцаагч Ө.Билгүүн, Ж.Рэнсмаа, Л.Мягмарсүрэн, Б.Ганзориг, Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Мөнхзул, хяналт, зохицуулалтын ажилтан Б.Даваахүү, Б.Ононгоо, “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ-ын Засвар үйлчилгээний хэлтсийн дарга Я.Дорждэрэм, Өрхийн зуухны инженер Б.Өлзийбаяр, Хийн хангамжийн инженер П.Анхбаяр, СБД-ийн АБТХ-ийн дарга Б.Болортуул зэрэг холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран хяналт шалгалт хийлээ. Үүнд:

Баянгол дүүрэгт 100-4200 кВт хүртэлх хүчин чадалтай уурын болон усан халаалтын 5 зуух бүртгэгдсэн. Тус дүүрэгт усан халаалтын зуух бүртгэгдээгүй, уур үйлдвэрлэх зохицуулалттай хувийн хэвшлийн 5 ААНБ-ын 5 уурын зуух бүртгэгдсэн. Үйл ажиллагаа түр зогссон 2 ААНБ байна. Бүртгэгдсэн ААНБ нь дулааны улиралд буюу 05 дугаар сараас 10 дугаар сар хүртэл үйл ажиллагаа явуулдаг, хаягдал утааны хэмжилт хийлгээгүй байна.

Баянзүрх дүүргийн 100-4200 кВт хүртэлх хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч иргэн, ААНБ-д 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдөр, 03 дугаар сарын 03, 04, 05-ны өдрүүдэд хяналт, шалгалт хийн ажилласан.

Хяналт шалгалтаар уурын болон усан халаалтын 24 байршлын 56 зуух бүртгэгдсэн. Бүртгэгдсэн 56 зуухнаас хийн халаалтад шилжсэн ЗХЖШ-ын харьяа 189, 015 ангиудын 5 зуух байна.

Хяналт шалгалтаар Баянзүрх дүүрэгт төрийн өмчит бүртгэлтэй усан халаалтын 27 зуух, уур үйлдвэрлэх 2 зуух, хувийн өмчит бүртгэлтэй усан халаалтын 20 зуух, уур үйлдвэрлэдэг 2 зуух бүртгэгдсэн. Уурын болон усан халаалтын 51 зуух ашигладаг ААНБ-ууд нь зуухны паспортыг эрчим хүчний байцаагчаар

баталгаажуулаагүй, хаягдал утааны хэмжилтийн дүн MNS5919:2008 стандартын шаардлага хангаагүй болон хэмжилт хийлгээгүй, дулааны цахилгаан станц, уурын болон усан халаалтын зуух ашиглалтаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудасны шаардлага хангагдаагүй байна.

Иймд ААНБ-уудад хаягдал утааны хэмжилт хийлгэх, зуухны бүрэн бүтэн байдал болон зуухны паспортыг эрчим хүчний байцаагчаар баталгаажуулах талаар зөвлөгөө өгч улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж ажилласан.

Налайх дүүрэгт 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр 3 ажлын хэсэг 100-4200 кВт хүртэлх хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч иргэн, ААНБ-д хяналт шалгалт хийн ажилласан.

Хяналт шалгалтаар Налайх дүүрэгт 33 байршлын уурын болон усан халаалтын 62 зуух бүртгэгдсэн. Бүртгэгдсэн 62 зуухнаас ЗХЖШ-ын харьяа 310 дугаар цэргийн ангийн 1 зуух хийн халаалтад шилжсэн. Үйл ажиллагаа түр зогссон тоосгоны 2 үйлдвэр бүртгэгдсэн.

Налайх дүүрэгт төрийн өмчит бүртгэлтэй усан халаалтын 21 зуух, хувийн хэвшлийн 23 усан халаалтын зуух бүртгэгдсэн. Уур үйлдвэрлэх буюу технологийн зориулалтаар зуух ашиглан үйл ажиллагаа явуулж буй 10 ААНБ-ын 15 зуух бүртгэгдсэн.


Магадлан итгэмжлэх боломжтой “Нэйшнл Майнинг Машинери” ХХК-ийн нэг зуух байна. Бусад ААНБ нь зуухны паспорт эрчим хүчний байцаагчаар баталгаажаагүй, хаягдал утааны хэмжилтийн дүн MNS5043:2016 стандартын шаардлага хангаагүй болон хэмжилт хийлгээгүй байна. Мөн дулааны цахилгаан станц, уурын болон усан халаалтын зуух ашиглалтаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудасны шаардлага хангахгүй үзүүлэлт гарсан.

Сүхбаатар дүүрэгт 2026 оны 02 дугаар сарын 05, 03 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд хяналт шалгалтаар ажилласан. Хяналт, шалгалтаар уурын болон усан халаалтын 17 байршлын 28 зуух бүртгэгдсэн. Бүртгэлд хамрагдсан 28 зуухнаас 1 зуух цахилгаан халаалтад шилжиж, 27 зуух үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн өмчид бүртгэлтэй усан халаалтын 10 зуух, хувийн өмчид бүртгэлтэй усан халаалтын 16 зуух бүртгэгдсэн байна. Уур үйлдвэрлэх технологийн зориулалтаар зуух ашигладаг 1 ААНБ-ын 1 уурын зуух бүртгэгдсэн. Сүхбаатар дүүрэгт байрлалтай 27 уурын болон усан халаалтын зуухнуудын хаягдал утааны хэмжилтийн дүн MNS5919:2008 стандартын шаардлага хангаагүй болон хэмжилт хийлгээгүй, зуухны паспорт эрчим хүчний байцаагчаар баталгаажаагүй, дулааны цахилгаан станц, уурын болон усан халаалтын зуух ашиглалтаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудасны шаардлага хангагдаагүй шалтгаануудаар магадлан итгэмжлэх боломжгүй гэж үзэн эх үүсвэрийн тооллогод бүртгэн ажилласан.

“Алтанжолоо трейд” ХХК болон “Омега” ХХК-ийн Номун амралт нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан ба Зөрчлийн тухай хуулийн 7.1.2 дах заалтыг зөрчсөн тул торгуулийн арга хэмжээ авсан. Бусад ААНБ-уудад хаягдал утааны хэмжилт хийлгэх, зуухны бүрэн бүтэн байдал болон зуухны паспортыг эрчим хүчний байцаагчаар баталгаажуулах талаар зөвлөгөө өгч шаардлагатай тохиолдолд улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар хүргүүлж ажилласан.

Сонгинохайрхан дүүрэгт 2026 оны 03 дугаар сарын 03, 04, 10-ны өдрүүдэд, 04 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд хяналт шалгалтаар ажилласан. Хяналт шалгалтаар уурын болон усан халаалтын 71 байршлын 105 зуух бүртгэгдсэн. Бүртгэгдсэн 105 зуухны 3 байршлын 6 зуух нь хийн халаалтад шилжсэн, үйл ажиллагаа түр зогссон 18 ААНБ-ын 18 зуух бүртгэгдсэн. Хяналт шалгалтаар Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн үйл ажиллагаа явуулж буй уурын болон усан халаалтын 81 зуух байна. Усан халаалтын 38 зуух, уур үйлдвэрлэх технологийн зориулалт бүхий 43 зуух бүртгэгдсэн бөгөөд төрийн өмчид бүртгэлтэй 18 зуух, хувийн өмчид бүртгэлтэй 63 зуух байна.



Зураг 1. Ану сервис, ХИХУ 79-р сургуулийн 2 зуух

Зуух ашигладаг ААНБ-ууд нь зуухны паспортыг эрчим хүчний байцаагчаар баталгаажуулаагүй, хаягдал утааны хэмжилтийн дүн MNS5919:2008 стандартын шаардлага хангаагүй болон хэмжилт хийлгээгүй, дулааны цахилгаан станц, уурын болон усан халаалтын зуух ашиглалтаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудасны шаардлагыг хангаагүй байна.

Иймд ААНБ-уудад хаягдал утааны хэмжилт хийлгэх, зуухны бүрэн бүтэн байдал болон зуухны паспортыг эрчим хүчний байцаагчаар баталгаажуулах талаар зөвлөгөө өгч улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар хүргүүлсэн. Мөн түүхий нүүрс ашиглаж, зөрчил илэрсэн ААНБ-уудын түүхий нүүрсийг хурааж, торгуулийн арга хэмжээ авч ажилласан болно.

Хан-Уул дүүрэгт 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр, 03 дугаар сарын 05, 11, 25-ны өдрүүдэд 100-4200 кВт хүртэлх хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч иргэн, ААНБ-д хяналт шалгалт хийн ажилласан. Хяналт

шалгалтаар усан халаалтын 33 зуух, уур үйлдвэрлэх технологийн зориулалттай 4 зуух, хийн халаалтад шилжсэн 2, цахилгаанд шилжсэн 2 зуух нийт 21 байршлын 41 зуух бүртгэгдсэн. Хүснэгт 8-д Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй уурын болон усан халаалтын зуух ашиглагч иргэн, ААНБ-ыг жагсаалтаар харуулав.

Хяналт шалгалтаар Хан-Уул дүүрэгт бүртгэгдсэн 37 зуухнаас усан халаалтын 33 зуух, уур үйлдвэрлэх технологийн зориулалттай 4 бүртгэгдсэн. Төрийн өмчид бүртгэлтэй 17 зуух, хувийн өмчид бүртгэлтэй 20 зуух байна.



Зураг 2. Ургах наран хорооллын зуух

Бүртгэгдсэн зуухнаас хаягдал утааны хэмжилтийн дүн MNS5919:2008 стандартын шаардлага хангасан, зуухны паспорт эрчим хүчний байцаагчаар баталгаажсан, дулааны цахилгаан станц, уурын болон усан халаалтын зуух ашиглалтаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудасны шаардлага хангасан магадлан итгэмжлэх боломжтой “Шар доктор” ХХК-ийн зуух байна. Бусад ААНБ-уудад хаягдал утааны хэмжилт хийлгэх, зуухны бүрэн бүтэн байдал болон зуухны паспортыг эрчим хүчний байцаагчаар баталгаажуулах талаар зөвлөгөө өгч шаардлагатай тохиолдолд улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар хүргүүлж ажилласан.

Чингэлтэй дүүрэгт 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрүүдэд хяналт шалгалтаар ажилласан. Хяналт шалгалтаар 100-4200 кВт хүртэлх хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч 8 байршлын 16 зуух бүртгэгдсэн. Хийн халаалтад шилжсэн 5 байршлын 14 зуух бүртгэгдсэн. Галлагаатай 16 зуухны төрийн өмчид бүртгэлтэй 5 зуух, хувийн өмчид бүртгэлтэй 11 зуух байна.

Хяналт шалгалтаар Чингэлтэй дүүрэгт уур үйлдвэрлэх зуух бүртгэгдээгүй, усан халаалтын 16 зуух бүртгэгдсэн. Усан халаалтын зуух ашиглагч ААНБ-ууд зуухны паспортыг эрчим хүчний байцаагчаар баталгаажуулаагүй, хаягдал утааны хэмжилтийн дүн MNS5919:2008 стандартын шаардлага хангаагүй болон хэмжилт хийлгээгүй, дулааны цахилгаан станц, уурын болон усан халаалтын зуух ашиглалтаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудасны шаардлага хангаагаагүй байна.

Иймд ААНБ-уудад хаягдал утааны хэмжилт хийлгэх, зуухны бүрэн бүтэн байдал болон зуухны паспортыг эрчим хүчний байцаагчаар баталгаажуулах талаар зөвлөгөө өгч шаардлагатай тохиолдолд улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар хүргүүлж ажилласан.

ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ, АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалтаар ажиллахад дараах зөрчлүүд илэрсэн.

- “Алтанжолоо трейд” ХХК
- “Нью Пакс Монгол” ХХК
- “Омега” ХХК-ийн Номун амралт
- “Тэмүүлэн Од” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулж зөрчлийн тухай хуулийн 7.1.2 дах заалтыг зөрчсөн тул тус бүр 500,000 төгрөгийн торгууль ноогдуулсан.
- Иргэн Р.Саранчимэг
- Хадат вилла 1 сөх нь Байгаль орчны үнэлгээгээр тавигдсан нөхцөл шаардлага биелүүлж ажиллаагүй буюу зөрчлийн тухай хуулийн 7.1.3 дах заалтыг зөрчсөн тул иргэнийг 300,000 төгрөгөөр, ААНБ-д 3,000,000 төгрөгийн торгууль,
- “УНК” ХХК нь агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн ЗТХ 7.4-4 тул 1,500,000 төгрөгийн торгууль,
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх зөрчлийн тухай хуулийн 15.2-1-1.2 дах заалтыг зөрчсөн тул 500,000 төгрөгийн торгууль,
- “Баялаг тахиа” ХХК нь хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан буюу түүхий нүүрс ашигласан тул түүхийн нүүрсийг хураан авч, зөрчлийн тухай хуулийн 7.4-1.3 дах заалтын дагуу 3,000,000 төгрөгийн торгууль тус тус ногдуулж хугацаатай албан даалгавар хүргүүлж ажилласан байна.

ХЯНАСАН:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БОЛОРМАА

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Я.ДОРЖДЭРЭМ